

“ДЦС-4” ТӨХК

Огноо: **2019 оны 10 дүгээр сар 03**

**ЗООГИЙН ГАЗРЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Харьцуулалт/ гэрээний
дугаар: XXA-2019/29-3**

Нэг. **ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

ДЦС-IV ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ХХА-2019/29-3 Зоогийн газрын тоног төхөөрөмж нийлүүлэх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна. Тендер нь түүнийг нээсэн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2019 оны 10-р сарын 10-ны өдрийн 10.000 цагаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээх бөгөөд 1 хувийг цаасаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 10-р сарын 10-ны өдрийн 10.30-т** цахим системээр нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

“ДЦС-4” ТӨХК ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж
Захиргааны байр 3-р давхар 311,312 тоот өрөө
Утас:70181309, 7017-1357

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Унийн санал;
(б) Унийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) ТОӨЗ-д заасан шаардлагууд |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн Унийн саналаас татгалзана . |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Унийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь нэг багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Сүүлийн нэг жилийн санхүүгийн баталгаажсан тайлан</p> <p>Сүүлийн нэг жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага: Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2019 оны 10-р сарын 10-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минутаас өмнө</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn</p> <p><u>Сайтад илгээх бөгөөд нэг хувийг цаасаар ирүүлнэ</u></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот. Баянгол дүүрэг. 20-р хороо. “ДЦС-4” ТӨХК.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 310 тоот</p> <p>Огноо: 2019 оны 10 дүгээр сарын 10-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ХХА-2019/29-3 Зоогийн газрын тоног төхөөрөмж нийлүүлэх нэг багцаас бүрдэнэ

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

д/д	Төхөөрөмжийн нэр	Хэмж их нэгж	Тоо ширхэг	Зориулалт	Тоноглолын техникийн үзүүлэлт	Тайлбар
1	Хутга ариутгач	ш	5	Хутга, хэрчих мод, жижиг багажууд ариутгах	Их бие зэвэрдэггүй гангаар хийгдсэн. 220В-оор ажилладаг. Шилэн хаалгатай. Температур тохируулагчтай. Асах, унтрах гэрэлтэй.	Төв ЗГазар-3ш Үйлдвэрлэлийн хэсэг-1, мах бэлтгэл-1, Ногоо бэлтгэл-1 ТДЦ салбар-2ш хоол үйлдвэрлэл-1ш, бэлтгэл хэсэг-1 Нийт 5ш
2	Гурил элдэгч, хэрчигч машин	ш	2	Төрөл бүрийн гурилан бэлдэц бэлтгэх.	Их бие нь зэвэрдэггүй гангаар хийгдсэн, ирний хамгаалттай, нарийн, бүдүүн 2 иртэй. Ирийг сольдог. 220В-оор ажилладаг. Хурд болон ирний тохируулагчтай. Гурил элдэх, хэрчих зориулалттай.	Зоогийн газар нь өдөрт 1000-1200 хүн хооллодог бөгөөд өдөр бүр гурилтай шөл үйлдвэрлэдэг. Мөн бусад төрлийн гурилтай хоолнуудыг хийхэд өдөр бүр 10-50кг гурилыг бэлтгэх шаардлага гардаг бөгөөд гурил, элдэгч хэрчигч машин нь өдөр бүр тасралтгүй 5-8 цаг ажилладаг.
3	Хөргөгч	ш	1	ТДЦ салбарт хоолны дээж хадгалах	Шилэн нүүртэй, шаталсан тавиуртай, Температур хэмжигчтэй. Цагаан өнгөтэй.	
4	Жигнүүр	ш	1	Бүх төрлийн хүнсийг уураар жигнэж болгох	Зэвэрдэггүй гангаар хийгдсэн цэвэр устай шууд холбох боломжтой. Хэмжээ: 1580*860*1530 Хүчин чадал: 3*12KW. 12 тавиуртай, тавиурууд нь жижиг нүхтэй байх. 220В-380В-р ажилладаг байх.	
5	Махны машин	ш	1	Мах машиндах	380 вольтоор ажилладаг. 1.5 квт-ийн хүчин чадалтай. 1 цагт 600кг мах машиндах хүчин чадалтай. 1,2-р хуттыг зэрэг ажиллуулах боломжтой. 3 төрлийн шүүртэй. Буцах кнопкай байх.	

6	Max зорогч	ш	1	Max зорох, бэлдэц бэлтгэх	Моторын эргэлт 1400, хутганы хэмжээ 32см, 220 вольтоор ажилладаг. Бүрэн автомат, зэвэрдэггүй гангаар хийгдсэн	
7	Яс хөрөөдөгч	ш	1	Өвчүү, хавирга гм ястай хэсгүүдийг жижиглэх	Тавцангийн хэмжээ 47*53см, 1980мм урттай хөрөөний иртэй, 380 вольтоор ажилладаг.	
8	Их тосонд шарагч	ш	1	Бүх төрлийн шарсан хүнс, бэлдэц бэлтгэх	9квт-ийн хүчин чадалтай., 380-вольтоор ажилладаг. Зэвэрдэггүй гангаар хийгдсэн. 60-80литрийн багтаамжтай	
9	Гурил зуурагч	ш	1	Гурилан зуурмаг бэлтгэх	Зэвэрдэггүй ган материалыаар хийгдсэн. 1.7квт хүчин чадалтай, Цэвэр тэмрөөр хийсэн араануудтай. Зуурагчийн багтаамж 60л ба түүнээс их, нэг удаад хөөлттэй 16кг, хөөлтгүй 25кг зуурмаг зуурах буюу цагт 200кг гурил зуурах хүчин чадалтай 2 төрлийн хурдаар ажилладаг.	
10	Хоол халуун байлгагч	ш	1	Хоолыг халуун байлгах	Зэвэрдэггүй гангаар хийгдсэн. 3квт тенytэй. 6 тасалгаатай байх. Халуун байлгагч савнууд 800гр-аас доошгүй жинтэй.	
11	Телевиз	ш	3	Цэсний самбар гаргах	48-50 инч, смарт тв байх.	Хоолны цэсний программтай шууд холбогдох учир заавал смар байх.

[огноо]

“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захидал Ү.Төмөрхуяг танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нэгж үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу захиалгаар нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа [нэг] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. Зах зээлийн үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд өрсөлдөгч компаниудын үнийн харьцуулалтыг үндэс болгоно
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Захиалагч чанарын баталгааны бичиг, худалдан борлуулах зөвшөөрлийг шалгана.
1.2. Нийлүүлэх барааны сав, баглаа боодол нь баталгаажсан эсэхийг шалгана |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;
2) барааны гарал үүслийн гэрчилгээ.
1 жилийн хугацаанд саадгүй нийлүүлнэ. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн болон ашиглалтын явцад баглаа боодол гэмтсэн, чанар өнгө үзэмж алдагдсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Нийлүүлэгчид Урьдчилгаа төлбөр олгохгүй бөгөөд гэрээгээр нийлүүлсэн барааны төлбөрийн нэхэмжлэх зарлагын баримт, холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч бараа хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төлбөрийг хийнэ. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны үнийн дүнд хэтэрсэн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хоног дутамд 0,1%-ийн алданги ноогдуулна.</p> <p>Захиалагч нийлүүлэгчийн төлбөрийг хугацаа хоцроосон тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хэтэрсэн хоног дутамд 0,1%-ийн алданги ноогдуулна.</p> <p>Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 30%-аас хэтрэхгүйбайна.</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ДЦС-4 ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

ЗАХИРАЛ

ЗООГИЙН ГАЗРЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас “**ДЦС-4” ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **Зоогийн газрын тоног төхөөрөмж нийлүүлэх ХХА-2019/29-3** г (цаашид “бараа” гэх) (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч 3 сарын хугацаатай гэрээг байгуулав.. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь барааг захиалагчийн захиалгын дагуу нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:“ДЦС-4” ТӨХК-ИЙН

ХААХ-ИЙН ДАРГА:
ЭЗГ-ИИН ДАРГА:

О.ГАНТӨМӨР
Я.ГЭРЭЛМАА

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“.....” ХХК-ИЙН

МЕНЕЖЕР

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Ч.БЯМБАСҮРЭН

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

С.ДОНИД

